



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны A/22 дугаар тогтоолын хэлэлцэх асуудлын 1.4 дэх хэсэгт “Дүүргийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг нэмж хэлэлцүүлсүгэй.

2. Дүүргийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулах хуулийн шаардлагад нийцүүлж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны A/22 дугаар тогтоолын тэргүүг Хурлын хуралдаан хуралдуулах тухай, мөн тогтоолын нэгдүгээр хэсэгт ээлжит бус хуралдаан гэснийг ээлжит наймдугаар хуралдаан гэж тус тус өөрчилсүгэй.

3. Энэхүү шийдвэрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Батболд, Засаг дарга Ж.Сандагсүрэн нарт хүргүүлж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Н.Мөнхбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХЦЭЦЭГ